

PLITONIT

МЭРГЭЖИЛТЭН БАЙХ АМАРХАН



PLITONIT C Мрамор – ОХУ-ын стандарт хэмжилзүйн ГОСТ Р 56387 стандарт C2 TE ангиллын гантиг, шилэн, мозайкийн цагаан цавуу



Энэхүү хольц нь гадна болон дотоод заслын өнгөлгөөний ажилд ямар ч төрлийн гантиг, мозайк, шилэн хавтанг хиймэл болон байгалийн чулуугаар хийсэн хавтанцар, түүнчлэн бетон, агааржуулсан бетон, тоосго, гөлтгөнө хавтан, цементэн гөлтгөнөөр хийсэн гадаргуу дээр наахад зориулагдсан.

"Халдаг шал" системд хэрэглэнэ. Бүх төрлийн хэмжээтэй усан сангийн өнгөлгөөнд тохирно. Цавуунд тусгай нэмэлтийг хэрэглэх нь цагаан хаг тогтохоос сэргийлж, тунгалаг хавтангийн өнгө өөрчлөгдөхөөс сэргийлдэг. Цавууны Супер цагаан өнгө бүх ашиглалтын хугацаанд өөрчлөгдөхгүй. Нарийн ширхэгтэй бүтэцтэйгээс, бас хавтан хооронд үе чигжих, цементлэх ашиглаж болно. Гүйцэтгэлийн явцад хавтан нь босоо гадаргуугаас гулсдаггүй бөгөөд энэ нь өнгөлгөөний ажлыг "дээрээс доош" гэх мэт аль ч чиглэлд өнгөлгөөг хийх боломжийг өгдөг. Нийтийн эзэмшлийн талбай, орон сууц, тэр дундаа сургууль, цэцэрлэг, эрүүл мэндийн байгууламж (эмчилгээ, урьдчилан сэргийлэх, амралт-сувиллын байгууламжууд)-д хэрэглэж болно.

Савлагаа — 25 кг, 4 кг.

- хэвийн хадгалалтын үед өндөржүүлсэн барьцалдах чадвартай –1,4 МПа
- усны орчинд өндөржүүлсэн барьцалдах чадвартай, өндөр ба бага температурт – 1,2 МПа
- супер цагаан өнгө
- нээлттэй хугацааг уртасгасан – 30 минут
- Хүйтэнд тэсвэртэй байдлын зуурмагийн марк, – F150

Бүтээгдэхүүний зарцуулалт

1 мм зузаантай түрхэх үеийн зарцуулалтын хэмжээ нь ойролцоогоор 1,3 кг/м² байна

Хавтангийн хамгийн урт талын урт, мм	108 хүртэл	109-200	201-250	251-300	300-аас эхлэн
Хусуурын ховилын гүн, мм	4	6	8	10	12
Хуурай хольцын зарцуулалт 1 м ² талбайд, кг-аас	2,65	3,98	5,3	6,63	7,95
25 кг цавуу ашиглан суурилуулсан хавтангийн талбай, м ² -аас	9,4	6,3	4,7	3,8	3,1

Материалын зарцуулалтыг алдагдлыг тооцохгүйгээр тэгш гадаргуу дээр тавьж ажиллах үед тооцоолсон бөгөөд түрхсэн арга, суурийн тэгш бүс байдал, ажил гүйцэтгэж буй хүний мэргэжлийн үр чадвар зэргээс хамаарч зарцуулалт өөр байж болно.

Ажлын нөхцөл

Ажлын явцад болон гүйцэтгэлийн дараа 3 хоногт агаар, суурь, хавтангийн температур +5 хэмээс + 30 хэмд байх ёстой. Ажлын явцад зуурмаг хольцын температур +10 хэмээс +30 хэмд байх ёстой.

Гадаргууг бэлтгэх

Гадаргуу нь бат бэх байх шаардлагатай, ажил эхлэхээс өмнө гадаргууг сайтар цэвэрлэх (тоос, шороо, шохой, тос болон тослог гадаргуу, битум, органик болон эрдэс бүхий наалдамхай бодис, будгийн үлдэгдэл, түүнчлэн усанд уусдаг бодис) шаардлагатай. Гөлтгөнө суурь гадаргуу болон ус шингээх чадвар өндөртэй гадаргууг өнгөлөхдөө үйлдвэрлэгчийн зааврын дагуу ажил эхлэхийн өмнө PLITONIT хөрсжүүлэгчээр бүрсэн байх шаардлагатай. Цаашдын ажлыг хөрсжүүлэгч бүрэн хатсаны дараа гүйцэтгэнэ.

Зуурмагийн хольц бэлтгэх

Хуурай хольцыг нийлүүлж холихдоо нийтийн усны хангамжийн усыг ашиглах боломжтой. Холих харьцаа нь 1 кг хуурай цавууны хольцод 0,23-0,28 литр (1 уут буюу 25 кг-д 5,75 - 7,0 литр) ус шаардагдана. Хуурай хольцыг тасалгааны температурт урьдчилан хэмжсэн зохих хэмжээний ус уруу хийнэ, нэгэн төрлийн жигд болтол нь 2-3 минутын түрш эргэлтийн хурд нь 600 эргэлт/мин-ээс ихгүй байх цахилгаан холигч эсвэл цахилгаан өрмийн тусламжтайгаар холино. Зуурмагийг ойролцоогоор 5 минут амраан дахин холино. Энэ үед зөвшөөрөгдсөн хамгийн дээд хэмжээний үлдсэн усыг нэмж хэрэглэж болно. Бэлэн зуурмагийг хэрэглэх хугацаа нь 4 хүртэлх цаг байх бөгөөд агаарын хэт халалт болон нэвт салхижуулалт энэ хугацааг багасахад нөлөөлнө.

Ажлын дараалал

Ажил гүйцэтгэхдээ СП 71.13330 (7-р хэсэг) стандартын шаардлагыг дагаж мөрдөх шаардлагатай. Бэлтгэсэн зуурмагийг суурийн гадаргуу дээр жигд тараан, гөлгөр хусуураар түрхэж ховилтой хусуураар долгион гаргах байдлаар түрхэнэ (ховилын хэмжээ нь хавтангийн хэмжээ, төрлөөс хамаарна). Зуурмагийг асгаснаас хойш 30 минутын (ажил гүйцэтгэх хугацаа) дотор хавтанг наах боломжтой байдлаар тооцон гүйцэтгэнэ. Хавтанг зуурмаг дээр тавихдаа бага зэрэг эргүүлэх байдлаар сайн дарж тавина. Хавтангийн байрлалыг дараагийн 30 мин дотор тохируулж, янзалж болно. Өрөөний агааржуулалт, дулаан, гадаргуун чийг шингээх чадвараас шалтгаалан дээрх хугацаа өөрчлөгдөж болно. Хэрэв хэрэглэсэн цавууны гадаргуу дээр хатсан царцдас үүссэн бол зуурмагийг гадаргуугаас хусаж аван шинээр сольж хийх шаардлагатай. Хавтан нь нээлттэй залгалтаар тавьж, зохих бэхэлгээгээр тэгшилнэ. Усан сан, байгууламжийн нүүрэн тал, террас, тагт, халдаг шал, түүнчлэн арын овгорын өндөр нь 2 мм-ээс дээш эсвэл 30х30 см-ээс дээш хэмжээтэй хавтангуудаар өнгөлгөө хийх үед хавтангийн доорх хоосон зайнаас зайлсхийх, наалдуулах бат бөх чанарыг нэмэгдүүлэхийн тулд хосолсон байдлаар (суурь ба хавтангийн ар талд) цавуу түрхэх шаардлагатай. Цавууг дээр дурдсанчлан суурь дээр хэрэглэнэ. Хавтангийн арын хэсэгт цавууг эхлээд ховилтой хусуураар түрхэж, дараа нь гөлгөр хусуураар хавтангийн бүх хэсэгт жигд тэгшилнэ. Тус хосолсон хэлбэрээр зуурмагийг ашиглах үед зарцуулалт нь 1 мм зузаантай түрхэхэд 1.3 кг/м² болж нэмэгддэг.

Мозайк хавтан суурилуулах

Цаасан дэвсгэр дээрх мозайкуудаар өнгөлгөө хийх үед нүүрэн талд нь наасан мозайкийн хуудаснуудын гадаргууд цавуу түрхэж, хуудас бүрийг бүх гадаргуугаар нь резинэн хусуураар жигд тэгшилнэ.

8 цагийн дараа цаасан суурийг чийгтэй хөөсөнцрөөр арчин арилгана. Энэ төрлийн мозайкийг гадна эсвэл устай харьцах гадаргуутай байгууламжид ашиглахыг зөвлөж байна. Өнгөлгөөнд ард талд нь наасан цаас эсвэл торон суурьтай мозайктай тулгарах үед мозайк хуудсыг цавуугаар нааж, дараа нь хуудас бүрийг бүх гадаргуу дээр резинэн хусуураар тэгшилнэ. Энэ төрлийн мозайк нь зөвхөн байгууламжийн дотор засалд устай холбоогүй өрөөнд ашигладаг. Мозайк хавтангийн хоорондох залгаасыг мозайк нааж дууссаны дараа 8 цагийн дотор бөглөнө.

Анхааруулга

Өнгөлгөөний хавтанг гадаргуу дээр байрлуулснаас хойш 8 цагаас багагүй хугацааны дараа дээгүүр нь алхах, чигжээс хийж болно. Шалны халаалтыг ажиллуулахыг ус чийгт тэсвэртэй хавтан дээр хийсэн тохиолдолд хавтанг нааснаас хойш 3-аас багагүй хоногийн дараа энэ үйлдлийг хийхийг зөвшөөрнө. Дээр заагдсан хугацаа нь орчны температур (20 ± 2)°C, агаарын харьцангуй чийгшил (60 ± 10)%-д үйлчлэх бөгөөд бусад үед хугацаа хэлбэлзэж болно. Ажлыг гүйцэтгэхдээ барилгын ерөнхий ажил гүйцэтгэх зааварчилга, барилга угсралтын ажилд мөрдөгдөх аюулгүй ажиллагааны зааварчилга дагаж мөрдөх ёстой. Хавтанг тавихаас өмнө дэвтээж болохгүй, хавтангийн арын хэсгийг тоос, шорооноос цэвэрлэх хэрэгтэй. Ажил гүйцэтгэх явцад зуурмагийг үе үе хольж байх ёстой. Бэлэн зуурмаг дээр нэмж ус хийхийг хориглоно. Зуурмагийн өнгө өөр байх нь тухайн бүтээгдэхүүний түүхий эдийн олборлолтоос шалтгаалах бөгөөд энэ нь бүтээгдэхүүний техник үзүүлэлт болон ашиглалтын шаардлагад нөлөөлөхгүй. Найрлагад бага хэмжээний бэхжүүлэх утас агуулсан байж болно.

Аюулгүй ажиллагаа

Хуурай хольц нь ОХУ-ын стандарт хэмжилзүйн газрын ГОСТ 12.1.007 стандартын дагуу аюулын 4-р (бага аюултай бодис) ангилалд хамаарна.

- Арьсанд хүрэх үед бага зэргийн цочрол үүсгэдэг. Нүдэнд хүрвэл цочрол үүсгэдэг.
- Хэрэглэхийн өмнө бүтээгдэхүүнийг ашиглах зааврыг уншина уу.
- Ажиллаж байхдаа бээлий, тусгай хувцас, нүдний хамгаалалт хэрэглээрэй.
- Ажлын дараа гараа нүүрээ сайтар угаана.
- Хүүхдийн гар хүрэхгүй газар хадгална уу.
- НҮДЭНД ХҮРСЭН ТОХИОЛДОЛД: Хэдэн минутын турш усаар болгоомжтой угаана. Хэрэв та контакт линз хэрэглэдэг бол үүнийг хийхэд хялбар бол авч, нүдээ үргэлжлүүлэн усаар сайтар зайлна. Хэрэв нүдийг цочрол арилахгүй бол эмчид хандана уу.

Тээвэрлэлт болон хадгалах нөхцөл

Хуурай хольцыг ачаа тээвэрлэх дүрмийн дагуу бүрхүүлтэй тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ. Хуурай хольцтой уутыг савлагааны аюулгүй байдал, чийгээс хамгаалсан хуурай өрөөнд хадгална. Бүтээгдэхүүний хадгалах хугацаа нь үйлдвэрлэсэн өдрөөс хойш 12 сар байна.

Орц, найрлага

Портландцемент, карбонат дүүргэгч, кварцын элс, холбогдох нэмэлт бүтээгдэхүүнүүд.

Үйлдвэрлэгчийн баталгаа

Хэрэглэгч энэ зааврын тээвэрлэлт, хадгалалтын нөхцөл, зааврыг дагаж мөрдсөн тохиолдолд хольц нь ОХУ-ын стандарт хэмжилзүйн ГОСТ Р 56387 стандарт С2 ТЕ ангиллын шаардлагад нийцэж байгааг үйлдвэрлэгч баталгаажуулж байна.

Үйлдвэрлэгч нь материалтай ажиллах технологийг дагаж мөрдөхгүй байх, түүнчлэн эдгээр зааварт заагаагүй зорилго, нөхцөлд ашиглах үед хариуцлага хүлээхгүй. ГОСТ 8.579-2002 стандартын дагуу цэвэр жингийн хазайлт байна. Бүтээгдэхүүнийг бүх төрлийн иргэний барилгад ашиглахыг зөвшөөрсөн. (Аэфф<370 Бк/кг байх ОХУ-ын Цацрагийн аюулгүй байдлын стандартууд НРБ-99/2009, ариун цэврийн дүрэм, журам СанПиН 2.6.1.2523-09 нийцсэн).

Техник үзүүлэлтүүд

Дүүргэгчийн хамгийн том ширхгийн хэмжээ	0,315 мм
Цавууны үеийн хамгийн их залгааны зузаан	10 мм
Холих усны хэмжээ 1 кг хольцод 4 кг хольцод 25 кг хольцод	0,23 0,28 л 0,92 - 1,12 л 5,75 - 7,0 л
Ажлын температурын горим	+5°C-аас +30°C хүртэл
Босоо гадаргуугаас хавтангийн гулгалт, багагүй	0,5 мм
Нээлттэй ажиллах хугацаа, багагүй	30 минут
Хавтанг засах, тохируулах хугацаа, багагүй	30 минут
Зуурмаг хольцын амьдрах чадвар	4 цаг
Зуурмагийн ажил хийх боломжтой болох хугацаа, дараа	24 цаг
Ашиглалтын үеийн температурын горим,	-50°C-аас +70°C хүртэл
Хүйтэнд тэсвэртэй байдлын зуурмагийн марк, багагүй	F150
Хуурай агаарт 28 хоногийн турш байлгасны дараа цавууны барьцалдах бат бөх байдал	≥1,4 МПа
Усан орчинд байлгасны дараа цавууны барьцалдах бат бөх байдал	≥1,2 МПа
Өндөр температурт байлгасны дараа цавууны барьцалдах бат бөх байдал	≥1,2 МПа
Циклээр хөлдөөх ба гэсгээсний дараа цавууны барьцалдах бат бөх байдал	≥1,2 МПа
ОХУ-ын стандарт хэмжилзүйн ГОСТ Р 56387 стандарт цавууны ангилал	C2 TE

25 кг ууттай бүтээгдэхүүний хувьд логистикийн мэдээлэл

Хувийн бар-код 4607013043893

Нэг багц дахь уутны тоо – 48 ширхэг

4 кг ууттай бүтээгдэхүүний хувьд Логистикийн мэдээлэл

Хувийн бар-код 4607013045958

Бүлэг бар-код 14607013045955

1 хайрцагт агуулагдах уутны тоо – 4 ширхэг

Нэг багц дахь уутны тоо – 168 ширхэг